ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН "БУС НУТГИЙН СОЁЛЫН ФОРУМ 2023: ХОЙД БУСИЙН СОЁЛЫН БҮТЭЭН БАЙГУУЛЛЫГ ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСООР ДЭМЖИХ НЬ" СЭДЭВТ ФОРУМД УРИЛГААР ОРОЛЦЛОО 2

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ТУЛУЗ КАПИТОЛИЙН ИХ СУРГУУЛИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА 4

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ БАЙРШИЛ ӨӨРЧЛӨГДЛӨӨ 8

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# Хууль зүйн мэдээ

*Баталсан хууль нь хүн бүрт тэгш үйлчилдэг төр л хамгийн тогтвортой оршдог.*

*Аристотель*

www.nli.gov.mn | Хууль зүйн мэдээ сонин | 2023.12.30

## "ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС" СЭТГҮҮЛИЙН ХЯНАН МАГАДЛАГААНЫ ХУРААМЖ 100,000 ТӨГРӨГ БОЛЛОО

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн хянан магадлагааны хураамж 2024 оны 1 дүгээр улирлын дугаар буюу 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 100,000 төгрөг болж нэмэгдлээ.

"Хууль дээдлэх ёс" сэтгүүл нь ашгийн төлөө бус сэтгүүл бөгөөд сэтгүүлийн зөвлөлийн гишүүдийн мэдлэг, ур чадвар, оюуны бүтээлч ажлыг зохист хэмжээнд үнэлэх үүднээс хянан магадлагааны хураамжийг ийнхүү нэмэгдүүлэх болсон юм.






## ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН "БҮС НУТГИЙН СОЁЛЫН ФОРУМ 2023: ХОЙД БҮСИЙН СОЁЛЫН БҮТЭЭН БАЙГУУЛЛЫГ ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСООР ДЭМЖИХ НЬ" СЭДЭВТ ФОРУМД УРИЛГААР ОРОЛЦЛОО

БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургууль санаачлан 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо зохион байгуулсан "Бүс нутгийн соёлын форум 2023: Хойд бүсийн соёлын бүтээн байгууллыг хууль дээдлэх ёсоор дэмжих нь" сэдэвт форумд Хууль зүйн үндэсний хүрээлэн урилгаар оролцлоо.

Тус арга хэмжээний нээлтэд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, доктор(Dr.jur) Х.Эрдэм-Ундрахыг төлөөлж Хүний эрх, олон улсын эрх зүйн болон харьцуулсан эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан мэндчилгээ дэвшүүлж үг хэлэв. Тус форум үндсэн ба 4 салбар хуралдаанаас бүрдсэн бөгөөд "Хятад-Монгол-Орос гурван улсын Эдийн засгийн коридорын эрх зүйн асуудал" сэдэвт салбар хуралдаанд эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан, эрдэм шинжилгээний ажилтан Э.Сэлэнгэ нар "Монгол Улсын хувийн эрх зүйн шинэтгэл ба эдийн засгийн хамтын ажиллагааны зарим асуудал" сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.




/Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн ухааны доктор, түүхийн ухааны доктор Д.Наранцогт, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан, эрдэм шинжилгээний ажилтан Э.Сэлэнгэ, Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор Т.Дайчин нар/




/“Бүс нутгийн соёлын форум 2023: Хойд бүсийн соёлын бүтээн байгууллыг хууль дээдлэх ёсоор дэмжих нь” сэдэвт форумын үндсэн хуралдаан/

Эрх зүйн түүх, соёлын өвийг эрхэмлэх, соёлын бүтээн байгууллыг хууль дээдлэх ёсоор дэмжих олон талт ажиллагааны арга замыг хөндсөн энэхүү форумд 100 орчим судлаач, мэргэжилтэн оролцов. Үүний хүрээнд “Хятад-Монгол-Орос гурван улсын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн эрх зүйн асуудал, цаашдын чиг хандлага болон хууль зүйн хамтын ажиллагааг сайжруулах хэрэгцээ, шаардлага, шийдвэрлэх боломжийг хөндсөн нь онцлог юм.




/“Хятад-Монгол-Орос гурван улсын Эдийн засгийн коридорын эрх зүйн асуудал” сэдэвт салбар хуралдаан/

## БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ТУЛУЗ КАПИТОЛИЙН ИХ СУРГУУЛИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА



Франц улсын Тулуз Капитолийн их сургуулийн зочин судлаач Чарльз Даган Хууль зүйн үндэсний хүрээлэнд 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр зочиллоо.

Тус уулзалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн дарга С.Билигсайхан оролцож хүрээлэнгийн үйл ажиллагаа, гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцов.

Тулуз Капитолийн их сургуулийн зочин судлаач Чарльз Даган нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийн урилгаар Монгол улсад хүрэлцэн ирсэн.

Мөн уулзалтад МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш М.Мөнхнаран(Ph.D), ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан Б.Сүнжидмаа нар байлцав.



## ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН ӨВӨР МОНГОЛЫН ИХ СУРГУУЛИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА ХӨГЖҮҮЛЭХ ХЭЛЭЛЦЭЭ ХИЙВ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн Хүний эрх, олон улсын эрх зүйн болон харьцуулсан эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан, Иргэний эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Э.Сэлэнгэ нар 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд зочилж, хамтын ажиллагааны хэлэлцээ хийв. Өвөр Монгол Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн талаас захирал, профессор Дин Фэн тэргүүтэй удирдлагын багаас гадна салбар эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хятад, монгол хос хэлтэй багш нарын бүрэлдэхүүн тус уулзалтад байлцлаа. Байгууллагууд өөрсдийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар танилцуулан, эрх зүйн судалгаа, сургалт, мэдээлэл, сурталчилгааны хүрээнд хамтран ажиллах чиглэл, боломжийн талаар санал солилцож, хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг хэлэлцсэн нь энэ удаагийн уулзалтын үр дүн юм. Тухайлбал, хувийн эрх зүй судлал, арилжаа, худалдааны эрх зүйн хууль тогтоомжийн судалгаа хийж, чанар, үр нөлөөг дээшлүүлэх тал дээр хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага их байгааг чухалчлан тэмдэглэсэн.




/Хууль зүйн үндэсний хүрээлэн, Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн хамтын ажиллагааны уулзалтад оролцогсдын төлөөлөл/




/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Э.Сэлэнгэ, эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Энх-Амгалан, Өвөр Монголын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор Т.Дайчин нар/

Талууд хууль тогтоомжийг хятад хэл дээр орчуулж хэвлүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж оролцох зэргээр хамтран ажиллаж ирсэн түүхэн ач холбогдлыг онцолж, харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж ажиллахаа харилцан илэрхийлсэн болно.

Мөн судлаач Б.Энх-Амгалан, Э.Сэлэнгэ нар Өвөр Монголын Их Сургууль болон тус сургуулийн Хууль зүйн сургуулийн үйл ажиллагаа, дэд бүтцийн бүтээн байгуулал, номын сангийн ажил үйлчилгээтэй танилцаж, туршлага солилцов.

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГААР ХЗҮХ-ИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АХЛАХ АЖИЛТАН Б.ЭНХ-АМГАЛАНГ “ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР ШАГНАЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 145 дугаар зарлигаар ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны төвийн Хүний эрх, олон улсын болон харьцуулсан эрх зүйн секторын ахлагч, эрдэм шинжилгээний ахлах ажилтан Баярмагнайн Энх-Амгаланг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнав.

Б.Энх-Амгалан нь 20 дахь жилдээ төрийн албанд мэдлэг чадвар, хүч хөдөлмөрөө дайчлан хууль зүйн шинжлэх ухаан, бодлого судлалыг хөгжүүлэх, чанар, үр нөлөөг дээшлүүлэх, үр дүнг эрх зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны эргэлтэд оруулах, хуулийн засаглал, эрх зүйн шинэтгэлийн үндэслэл бүрдүүлэх, хүний эрхийг хамгаалах, эрх зүйн боловсролыг дэмжих, хуульч, судлаачдыг бэлтгэх, эрх зүйг хөгжүүлэх олон талт оролцоог холбох үйлсэд төрийн албаны нэр хүнд, төрийн албан хаагчийн ёс зүй, соёлыг эрхэмлэн, тууштай, үр бүтээлтэй хүчин зүтгэж, өндөр амжилт гаргасныг үнэлж ХЗҮХ-ийн хамт олон уг шагналд тодорхойлсон.

Шагнал гардуулах ёслолын үеэр ХЗҮХ-ийн захирал, хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах баяр хүргэж хэлсэн үгэндээ “Б.Энх-Амгалан нь хууль зүйн бодлого судлалыг хөгжүүлэх, хууль тогтоомжийн шинжлэх ухааны үндэслэл боловсруулах, олон улсын эрх зүйн нийцлийг хангах, гадаад орнуудын сайн туршлагыг нутагшуулахад харьцуулсан эрх зүйг ашиглах болон Хууль зүйн үндэсний хүрээлэнг хөгжүүлэх, залуу судлаачдыг чадавхжуулах, судлаачдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар дэмжих, судалгааны ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр үр бүтээлтэй ажиллаж ирснийг онцлох нь зүйтэй” гэсэн юм. Тэрээр 2015 онд “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнагджээ.




# "ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС"

сэтгүүлд бүтээл хүлээн авч байна



Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 22 дахь жилдээ эрхлэн гаргаж буй хууль зүйн эрдэм шинжилгээ, онол, практикийн улирал тутмын "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2024 оны 1 дүгээр улирлын болон англи хэл дээрх тусгай дугаарт хуульч, эрдэмтэн, багш, судлаач Та бүхнийг эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлэхийг урьж байна.

Сэтгүүлд нийтлүүлэх өгүүлэл, нийтлэл нь "ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС" сэтгүүлийн журамд заасан эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна. (Сэтгүүлийн журмыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн цахим хуудаснаас орж үзнэ үү.)

*Жич: Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь эрдэм шинжилгээний багц цагт тооцогдоно.*




Бүтээл хүлээн авах хугацаа.

| | |
|---|---|
| Нэгдүгээр улирлын дугаарт нийтлэх бүтээлийг | I/31хүртэл |
| Англи хэл дээрх тусгай дугаарт нийтлэх бүтээлийг | X/31 хүртэл |

**Хянан магадлалын хураамж 100,000 төгрөг боллоо**

lawjournal@legalinstitute.mn 99247620




Хууль зүйн мэдээ

Улсын бүртгэлийн дугаар 1197

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Эко Интернэйшнл Трэйд тауэр барилгын 9 давхар, Хууль зүйн үндэсний хүрээлэн.

11-315789

www.nli.gov.mn

Бэлтгэсэн: Ц.Энхжин

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Нийгмийн даатгалын багц хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Тус хуулиудын онцлог зохицуулалтын талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн бэлтгэдэг "1800-1202" подкастаас сонсох боломжтой.






НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХТЭТГЭВРИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХТЭТГЭМЖИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ,МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ,ТӨЛБӨРИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

## Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаа явуулах байршил өөрчлөгдлөө



Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Эко Интернэйшнл Трэйд тауэр барилгын 9 давхарт